

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ
ЗҮЙН ХЭЛТСИЙН 2018 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
АЖЛЫН ТАЙЛАН**

2018.06.20

Тус хэлтэс нь хууль зүйн салбарын бодлого, зорилтын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилт, иргэдийн оролцоог дэмжиж соён гэгээрүүлэх, хууль, эрх зүйн туслалцаа, үйлчилгээг байгууллага, албан тушаалтан, иргэд, олон нийтэд хүртээмжтэй хэлбэрээр хүргэн, эрх зүйн зөвлөгөө мэдээллээр хангахын зэрэгцээ хэлтэс, агентлагийн удирдлагууд, сум, багийн Засаг дарга, сумдын орон тооны бус “Эрх зүйн хөтөч” багийн ахлагч буюу сумдын Засаг даргын тамгын газрын дарга болон бусад холбогдох албан тушаалтан, мэргэжилтнүүдийг хууль тогтоомж хэрэгжүүлэх, сурталчлах ажилд арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж, шаардлагатай мэдээллээр хангаж, тэднээс гаргасан санал хүсэлтийг тухай бүрд нь шийдвэрлэн, цаашид хэрэгжүүлэх ажлыг хэлтсийн жил, улирал, сарын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган 2018 оны эхний хагас жилд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн сан бүрдүүлэлт,
бүртгэн цэгцлэх ажлын гүйцэтгэл, иргэд, аж ахуйн нэгжид
цахим болон гар сангаас лавлагаа мэдээлэл өгсөн талаар


Тус онд эрх зүйн мэдээллийн өөрчлөлт хөдөлгөөний бүртгэлийн нэгдсэн санд нийт 148 эрх зүйн актыг бүртгэсэн ба үүнээс нэмэлт, өөрчлөлт орсон 72 хууль, Засгийн газрын тогтоол 15, УИХ-ын тогтоол 16, Үндсэн хуулийн цэцийн тогтоол 6, Ерөнхийлөгчийн зарлиг 11-ийг тус тус бүртгэн сангаа баяжуулж, өдөр тутмын болон хууль тогтоомжийг сурталчлан таниулах үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүчингүй болгосон, зүйл заалт хассан болон нэмэлт өөрчлөлт орсон нийт 91 хууль, тогтоомжид тухай бүр эрх зүйн ангилал хийн, тамга тэмдэг дарж баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Цахим болон гар сангаас лавлагаа мэдээллийг 23 иргэнд өгч, уулзалтын бүртгэлийг хөтөлж ажиллалаа.

№	Хууль тогтоомжийн нэр	Төрөл	Бүртгэсэн өдөр	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл
1	Хууль тогтоомжийн нэр	Төрөл	Бүртгэсэн өдөр	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл
2	Хууль тогтоомжийн нэр	Төрөл	Бүртгэсэн өдөр	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл
3	Хууль тогтоомжийн нэр	Төрөл	Бүртгэсэн өдөр	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл
4	Хууль тогтоомжийн нэр	Төрөл	Бүртгэсэн өдөр	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл
5	Хууль тогтоомжийн нэр	Төрөл	Бүртгэсэн өдөр	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл
6	Хууль тогтоомжийн нэр	Төрөл	Бүртгэсэн өдөр	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл
7	Хууль тогтоомжийн нэр	Төрөл	Бүртгэсэн өдөр	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл
8	Хууль тогтоомжийн нэр	Төрөл	Бүртгэсэн өдөр	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн төрөл

Аймгий Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлийг
хянаж санал дүгнэлт өгөх, тухайн жилд гаргасан захиргааны
хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг зохих журмын дагуу
хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны
төв байгууллагад хянуулж, бүртгүүлсэн талаар

“Аймгийн Засаг даргын захирамжийн төслийг хянах, баталгаажуулах, сумдын Засаг дарга, Засаг даргын эрхлэх хүрээний хэлтэс, агентлагийн дарга нарын баталсан эрх зүйн актыг хянах журам”-ын дагуу аймгийн Засаг даргаас эхний хагас жилийн байдлаар нийт 271 захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянаж, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангаж, төслийн шатанд захирамж боловсруулсан этгээдээр санал авах хуудас болон хяналтын дагалдах хуудсыг тойруулан, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга болон хэлтсийн дарга нараар хянуулан зөвшөөрөл авч хэвшсэн. “Хууль зүйн салбарын Нээлттэй бодлого”-ыг



ДУНДГОВЬ АЙМАГ
DUNDGOVI AIMAAG / УТГАГАТЭГЭЭН НЭГДСЭН САЛАН ХУУДС

■ ТАМГА ДУУЛАА ■ НУТГИЙН ТЭГЭЭДЭМЭ ■ ЭРХЭЙН НЭТЭД ■ МЭДЭГ ■ АЖЛЫН ДАМС ■ ИХ ТУДАЛАА

Засаг Даргын Захирамж

№	Дугаар	Тарчиг	Огноо
1	А/2018	Бурхандунгайн аймаг, сум, сумуудын ажил, хэргийг байгуулах тухай	2017-10-29
2	А/2018	Газар байгуулах тухай	2017-10-20
3	А/2017	Газар хэргийн төрөлөөг өөрчлөх тухай	2017-10-19
4	А/2016	Газар хэргийн төрөлөөг өөрчлөх тухай	2017-10-19
5	А/2015	Нөмөр нь тэр бүрдсэн хэрэгүүдэд дундаж хамтран ажиллах хэрэгт тэд Ажлын хэргийн төрөлөөг өөрчлөх тухай	2017-10-19
6	А/2014	Монгол Улсын иргэдэд газар хэргийн төрөлөөг өөрчлөх тухай	2017-10-19
7	А/2012	Хөдөлмөрийн төлбөрийн өсгөх тухай	2017-10-19

хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд эхний 5 сарын байдлаар 202 захирамжийг аймгийн www.dundgovi.gov.mn вэб сайтын эрх зүйн актууд цэсний Засаг даргын захирамжууд хэсэгт байршуулан иргэд, олон нийтэд сурталчлан таниулсан.

Аймгийн Засаг даргын баталсан захиргааны хэм хэмжээний актын шинж агуулсан “С.Буяаннэмэх тэмдэгтэн шалгаруулах журам”-ыг Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн дагуу боловсруулан, журмыг батлан гаргаж, хянуулахаар хүргүүлж, ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Сумын Засаг даргын шийдвэр хууль тогтоомжид нийцэж
буй эсэхэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг
арилгуулах талаар авсан арга хэмжээ

Тус оны эхний хагас жилийн байдлаар сумдын Засаг дарга нарын болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн дарга нараас батлан гаргасан эрх зүйн актуудыг хуваарийн дагуу хянах ажлыг зохион байгууллаа.

Тус хугацаанд сумдын Засаг дарга нараас 2018 оны эхний 1 дүгээр улиралд батлан гаргасан нийт 325 эрх зүйн актын хууль зүйн үндэслэлийг хянаж, зөрчлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлээд байна. Мөн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нийт 9 агентлагийн даргын батлан гаргасан нийт 295 тушаалыг хуваарийн дагуу хянаж, гарсан зөрчлийг арилгуулахаар зөвлөмжүүдийг тус тус хүргүүлж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллалаа. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга нарын батлан гаргасан эрх зүйн актыг энэ онд 2 удаа татан авч хянахаар хуваарийг батлуулсан.



Нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан эрх зүйн сургалт,
сурталчилгааны ажлын чанар, үр дүн, шинээр боловсруулж
буй хууль тогтоомжийн төслийн талаар хэлэлцүүлэг
зохион байгуулж, санал авсан талаар

Тус хугацаанд сум, байгууллага, иргэдийн санал хүсэлтээр эрх зүйн албан ба албан бус сургалтыг 8, сурталчилгааг 3, хэлэлцүүлэг 2 удаа тус тус зохион байгуулж 944 иргэнийг хамруулж, зөвлөгөө, лавлагаа, баримт бичиг боловсруулах чиглэлээр 23 иргэнд эрх зүйн туслалцаа үйлчилгээг үзүүлээ. Иргэд ихэвчлэн шүүхэд гомдол гаргах, хөдөлмөрийн харилцаа, гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүлийн харилцаа, иргэн байгууллага хоорондын маргаан, газрын маргаан, гэрээ байгуулах, хохирол нөхөн төлүүлэх, хулгайд эд зүйлсээ алдсан, өмгөөлөгч авах, тэтгэвэр тэтгэмж тогтоолгох, ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах, зөрчлийн тухай, хүний эрхийн тухай хууль тогтоомжуудаар ханддаг тул тус сэдвүүдээр гарын авлага бэлтгэх, сурталчлан таниулах ажлыг илүүтэй зохион байгуулж, төрийн албан хаагчдын болон иргэдийн эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлсэн үр дүнтэй жил байлаа. Үүнд:

➤ “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” үндэсний хөтөлбөр, “Иргэний эрх зүйн боловсрол” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Эрх зүйн хөтөч” орон тооны бус багийн ахлагч/сумдын ЗДТГ-ын дарга/ нарын үйл ажиллагааг эрчимжүүлж чадавхжуулах чиглэлээр эрх зүйн сургалтыг жил бүр зохион байгуулж хэвшүүлээ.

➤ Тус оны “Эрх зүйн хөтөч” багийн ахлагч буюу сумын ЗДТГ-ын дарга нарыг чадавхжуулах сургалтыг өргөжүүлэн 2018 оны 5 дугаар сарын 3-4-ний өдрүүдэд УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, МУ-ын Засгийн газар, Төрийн албаны зөвлөл, Архивын ерөнхий газар, МУИС-ийн Хууль зүйн сургуультай тус тус хамтран сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, хэлтэс, агентлагийн дарга, орлогч, тасгийн

дарга, ахлах мэргэжилтэн, хүний нөөц, дотоод ажил, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүд, сумдын ЕБС-ийн захирал, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн дарга, эрхлэгч нар, Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнууд нийт 350 орчим албан хаагчдад “Төрийн албаны сахилга, хариуцлага, манлайлал зөвлөгөөн”-ийг 5 дугаар сарын 3-ний өдөр зохион байгуулж, төрийн байгууллагууд хариуцлагын жилд аймгийн Засаг даргын илтгэл; Төсвийн сахилга хариуцлагын талаарх Аудитын газрын мэдээлэл; Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарах асуудал; Төрийн албан хаагчийн баримтлах зарчим, ёс зүйн тухайд; Төрийн албаны хуулийн шинэчлэл, үзэл баримтлал; Захиргааны ерөнхий хууль, захиргааны хэм хэмжээний акт; Албан хэрэг хөтлөлт, анхаарах асуудал; Удирдлагын зарим нэр төрлийн баримт бичгийг боловсруулж бүрдүүлэх нь; Төр, хувийн хэвшил, их сургуулийн хамтын ажиллагаа; 5 дугаар сарын 4-ний өдөр зөвхөн “Эрх зүйн хөтөч” орон тооны бус багийн ахлагч буюу сумын ЗДТГ-ын дарга нарт Төрийн албан хаагчийн хандлага, харилцааны соёл; Бүх шатны төсвийн захирагч, санхүү бүртгэлийн ажилтны сахилга хариуцлага, манлайлал; Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, өөрчлөлт /Малчин даатгуулагчийн, өндөр насны тэтгэвэр тэтгэмжийн тухай/”; Эрүүл зан үйлийг дэмжсэн “Архидалтгүй аймаг-Дундговь” дэд хөтөлбөр төслөөр; “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” үндэсний хөтөлбөр; Эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа, тайлан мэдээ гаргахад анхаарах асуудал; Захиргааны шийдвэрийн хувийн хэргийг яаж бүрдүүлэх, хяналтын дагалдах хуудсыг бий болгох зэрэг сэдвүүдээр тус тус зохион байгууллаа.



Сургалтын явцад малчны тэтгэврийн талаар сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нараар ахлуулсан зөвлөлийн үйл ажиллагааны талаар Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтарсан уулзалт ярилцлага зохион байгуулж, асуулт хариулт явагдлаа.

Сургалтын төгсгөлд Эрх бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагааны 2017 оны тайланг үнэлсэн үнэлгээг танилцуулан, цаг үеийн болоод хамтран ажиллах талаар Хууль, эрх зүйн хэлтсийн дарга санал солилцож, сургалтын үйл ажиллагааг дүгнэн сургалтыг хаав.

➤ Эрх зүйн хөтөч багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор сумын Засаг даргын тамгын газрын албан тушаалтан, албан хаагчдаас 2018 онд судлах, иргэд олон нийтэд сурталчлан таниулах хууль тогтоомжийн жагсаалтыг улирал бүр 6-7 хууль тогтоомжоор зохион байгуулахаар боловсруулан хүргүүлж, хяналт тавин, Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Гурвансайхан сумдад эрх зүйн сургалтыг хамтран зохион байгуулж, 1690 гаруй гарын авлага материал, арга зүйгээр ханган ажиллалаа.



➤ “Иргэний эрх зүйн боловсрол” аймгийн хөтөлбөрийн II шатны үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд Иргэдэд хууль тогтоомж сурталчлах “Хуулийн цаг” радио нэвтрүүлгийн байнгын удирдамжийг аймгийн Засаг даргаар батлуулан Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, хууль хяналтын байгууллагуудыг сар бүрийн 01-30-ны өдрүүдэд сард 1 удаа Аюулаас сэрэмжлүүлэх цогцолбор FM107.5-аар өдөр бүр иргэд, олон нийт, малчдад хууль тогтоомжийг сурталчлах ажлыг 2 дахь жилдээ зохион байгуулж байгаа бөгөөд хийгдэж буй радио нэвтрүүлгийн чанар, хугацаанд хяналт шинжилгээ үнэлгээний ажлын үзүүлэлтэд заалтаар тусган хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.



➤ Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Иргэдээ сонсоё” төрийн үйлчилгээ нэгдсэн өдөрлөг арга хэмжээг 2 дахь жилдээ Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумдад 2018 оны 4 дүгээр сарын 2-6-ны өдрүүдэд аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын дарга, аймгийн ЗДТГ-ын 3 хэлтсийн дарга, 3 хэлтсийн ахлах мэргэжилтнүүд, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 30 гаруй албан хаагчид төрийн захиргааны удирдлага, эрүүл мэнд, соёл урлаг, хууль эрх зүй, сургалт, сурталчилгаа, санхүү татвар,



статистик, улсын бүртгэлийн

үйлчилгээ зэрэг төрийн бүх төрлийн

үйлчилгээг хөдөөгийн малчид, иргэд, олон нийтэд нэг цэгээс хүргэж үйлчиллээ. Тус сумдад ажиллахдаа аймгийн Шүүхийн зохион байгуулагч, Цагдаагийн газрын ГХУС ахлах байцаагч, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн зэрэг ажилтнууд



иргэдтэй ганцаарчлан уулзаж хууль, эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөөг газар дээр нь үзүүлж, 6 төрлийн хууль тогтоомжоор хялбаршуулсан нугалбар бүхий 370 ширхэг гарын авлагыг иргэдэд түгээж сурталчилсан.

➤ Их газрын чулууны байгалийн цогцолборт хамгаалалтын захиргаа, Сайнцагаан сумын долоон цэцэрлэг, Хүмүүнлэг ЕБС-ийн багш, ажилчид нийт 90 гаруй хүнд Хөдөлмөрийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр зэргээр эрх зүйн албан бус сургалтыг зохион байгуулав.

➤ Аймгийн удирдах албан тушаалтнууд болон ЗДТГ-ын албан хаагчид, Эрх бүхий албан тушаалтнууд, Сайнцагаан, Гурвансайхан, Сайхан-Овоо сумдын 130 гаруй төрийн албан хаагчдад эрх зүйн сургалтуудыг “Төрийн албаны тухай хууль” /шинэчилсэн найруулга/;

“Захиргааны ерөнхий хууль”(Захиргааны ерөнхий хуулийн эерэг үр нөлөө; Захиргааны шийдвэрийн хувийн хэргийг яаж бүрдүүлэх, хяналтын дагалдах хуудсыг бий болгох талаар, Шийдвэр гаргахад анхаарах асуудал); “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” үндэсний хөтөлбөр; “Төрийн албаны стандарт, түүнийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд; Гүйцэтгэлийн удирдлага(Төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ);



Able.mn програм болон Дундговь аймгийн цахим хуудасны ашиглалтын талаар; “Авлига, ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль”; “ХАСХОМ”; “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг”; “Ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдэгдэл, тайлбар гаргах” зэрэг хууль тогтоомжуудоор зохион байгууллаа.

➤ Тус хугацаанд 2018-2020 онд хэрэгжүүлэх “Архидалтгүй аймаг-Дундговь” дэд хөтөлбөрийг боловсруулан аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, уг хөтөлбөрийн нээлтийг сумдын Багийн Засаг дарга нарын цугларалтаар зохион байгуулж, зорилго, зорилтууд, арга хэмжээнүүдийг яаж хэрэгжүүлэх болон тус оны төлөвлөгөөг тус тус танилцуулан сурталчиллаа.



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр

зохион байгуулсан ажлын үр дүн

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хуралдаанаар өнгөрсөн оны ажлын тайлан болон 2018 онд хэрэгжүүлэх 3 бүлгийн 33 асуудал бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн баталж, сум, байгууллагуудад хүргүүлэн, төлөвлөгөөний явцад хяналт тавьж эрчимжүүлэн, зохион байгуулж буй ажлын мэдээг аймгийн www.dundgovi.gov.mn, www.khural.mn, Хууль, эрх зүйн хэлтсийнхэн сайтуудад тус

тус байршуулан сурталчилж байна. Тус хугацаанд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын салбар зөвлөлийн ээлжит хурлаар зөвлөлийн 2018 онд батлагдсан төлөвлөгөөнд нэмэлт тодотгох санал, аймгийн зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийн дагуу хийх ажлын төлөвлөгөөнд тусгах санал, замын хөдөлгөөний аюулгүй байдлын Говийн бүсийн зөвлөгөөний талаарх мэдээлэл зэрэг асуудлаар хуралдаж зохих шийдвэр гарган хэрэгжүүлж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд олон нийтийн хамтын ажиллагааг хангах, бэхжүүлэх зорилгоор “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд олон талт хамтын ажиллагаа” аймгийн зөвлөгөөнийг 2018 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгууллаа. Зөвлөгөөнд ХЗДХЯ-ны ГХУСАЗЗАА, аймгийн ИТХ, ГХУСАЗСЗ, аймгийн ЗДТГ болон хууль сахиулах байгууллагуудын албан хаагчид, сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга, хэсгийн мөрдөгч нар оролцож тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэж үзэл бодол, саналаа нэгтгэн ярилцаж зөвлөгөөнөөс зөвлөмж гарган баталж, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Уг зөвлөмжид аймаг, сумын хэмжээнд хийгдэх ажлыг тусгаж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.



2018 оны эхний хагас жилд аймгийн ГХУСАЗСЗ дараах гол ажлуудыг хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Улсын хэмжээнд болон орон нутгийн хэмжээнд нэгдсэн арга хэмжээ 6, тусгай арга хэмжээг 13-ыг зохион байгуулж биелэлт үр дүнг нь тооцсон.
- Сумдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, сумдын ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор 15 сумын ИТХ-д 8.0 сая төгрөг олгохоор шийдвэрлэж, хагас жилийн байдлаар ажлын үр дүнг тооцон сумдад 6.0 сая төгрөгний санхүүжилтийг олгосон.
- "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын төлөө" говийн бүсийн зөвлөгөөнд аймгийн ИТХ-ын дарга С.Сүхбаатар, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Б.Түвшинбаяр, Цагдаагийн газрын дарга Ц.Сугаржав нарын 6 албан тушаалтан оролцсон. Зөвлөгөөнд аймгийн ИТХ-ын дарга С.Сүхбаатар "Зам тээврийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 2018-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээ" сэдвээр, Цагдаагийн газрын дарга Ц.Сугаржав "Замын хөдөлгөөний өнөөгийн нөхцөл байдал, зам тээврийн гэмт хэрэг, ослын гаралт, түүний шалтгаан нөхцлийн талаар" мэдээлэл хийж, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар сум, байгууллагуудыг удирдлагаар хангаж хамтран ажиллаж байна.
- 2018-2020 онд хэрэгжүүлэх “Архидалтгүй аймаг-Дундговь” дэд хөтөлбөрийг боловсруулан аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хэрэгжүүлэх төлөвлөгөөний хамт батлууллаа. Уг хөтөлбөрийн гол зорилго нь аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, хорт зуршлаас сэргийлэх,

эрүүл зан үйл төлөвшүүлэхэд төрийн болон ТББ, иргэд, аж ахуй нэгжийг идэвхтэй татан оролцуулж, дэмжлэг үзүүлж, зохион байгуулалтаар хангаж архидалтаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх сөрөг үр дагаварыг бууруулах юм. “Архидалтгүй аймаг-Дундговь” дэд хөтөлбөрийг “Тамхи архины шалтгаант эмгэг судлалын төв” ТББ, “Монголын Эрэгтэйчүүдийн хөгжлийн нийгэмлэг” ТББ зэрэг архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон ТББ-тай хамтран хэрэгжүүлэхээр төсөл, хөтөлбөр боловсруулаад байна.



➤ Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2018 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн Шүүхийн шинжилгээний албаны криминалистикийн хэсэгт шаардлага хангасан Epson L1800 A3 фото принтер, аймгийн Прокурорын газарт зургийн аппарат, Аймгийн Цагдаагийн газрын эргүүлийн автомашиныг засварлахад 5.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

➤ 2017 онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд зохион байгуулсан “Гэмт хэрэг зөрчилгүй-Аюулгүй амар тайван орчин” аяныг дүгнэж үр бүтээлтэй ажилласан 5 сум, 3 аж ахуй нэгж байгууллагыг 4,8 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан.

➤ Бага насны хүүхдүүдэд замын хөдөлгөөний мэдлэг олгох, хөдөлгөөнд соёлтой оролцох дадлага эзэмшүүлэх, тэднийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дунд “Замын хөдөлгөөний цагаан толгой-2018” тэмцээнийг зохион байгуулж Зөвлөлөөс 600,0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаарх бодлого,
шийдвэрийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, архивын тасгаас
хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж,
мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, архивын сан
хөмрөгийн хадгалалт, архив, албан хэрэг хөтлөлтийн
ажлыг сайжруулах чиглэлээр хийсэн ажлын талаар

Архивын тухай хуулийн 23.1.9-д заасны дагуу тус аймгийн архиваас 2018 онд нөхөн бүрдүүлэлт хийх 11 сум, байгууллагын жагсаалт графикийг гаргаж холбогдох сум, байгууллагад хүргүүлж хэрэгжилтийг хангаж ажилласны дүнд эхний хагас жилд 3 хөмрөг үүсгэгчийн 55 хадгаламжийн нэгжийг аймгийн архивт хүлээн авч архивт баримт хүлээн авсан бүртгэл, актыг зааврын дагуу хөтлөж архивын сан хөмрөгөөр ангилан төрөлжүүлж хөмрөгт байрлуулсан.

МУ-ын Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу 9 шинээр ашиглалтанд оруулсан болон барилгын засвар, өргөтгөлийн үйл ажиллагаанд улсын комиссын бүрэлдэхүүнд орж 36 хадгаламжийн нэгжийг зохих журмын дагуу хүлээн авч акт, жагсаалтыг үйлдэж байрлуулав.

Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2018 оны А/09 тоот тушаалаар батлагдсан “Малчдын өндөр насны тэтгэвэр тогтооход баримтлах заавар”, Архивын Ерөнхий газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу сумдын ЗДТГ-аас мал тооллогын бүртгэлийг төрийн архивт шилжүүлэн авах графикийг сумдад хүргүүлж хэрэгжилтийг хангаж ажилласны дүнд 10 хөмрөг үүсгэгчийн 300 гаруй хадгаламжийн нэгж буюу мал тооллогын баримтыг төрийн архивт хүлээн авсан.

Аймгийн архивын дэргэдэх Баримт бичиг Нягтлан Шалгах Арга зүйн комиссын хурлыг 2018 оны эхний хагас жилд 3 удаа хуралдаж аймгийн архивт нөхөн бүрдүүлэлт

хийх байгууллагын жагсаалт, хуваарь болон сум, байгууллагын байнга хадгалах баримтын данс, бүртгэл, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, хадгалах хугацаа дууссан баримтын устгах хэргийн акт зэрэг 5 байгууллагын 6 асуудлыг хянан хэлэлцэн батлаж хариуг холбогдох сум, байгууллагад хүргүүлэв. 11 хөмрөг үүсгэгчийн данс бүртгэлд шинж чанарын үзлэг хийж 7 хөмрөгийн 7 хадгаламжийн нэгж буюу хосгүй үнэт баримтыг илрүүлж хосгүй үнэт баримтын бүртгэлд бүртгэж нийт 18 хөмрөгийн хосгүй үнэт баримтын бүртгэл жагсаалтыг гаргаж АЕГ-ын дэргэдэх ББНШТК-ын хурлаар хэлэлцүүлж батлуулахаар хүргүүлээд байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2018 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Төрийн архивын баримтын хадгалалт, хамгаалалтын тохиромжтой нөхцлийг бүрдүүлэх, аюулгүй байдлын баталгааг бий болгох, архивын шаардлага хангасан өрөө тасалгааг нэмэгдүүлж тохижуулах, өрөөнүүдийн гэрэлтүүлгийг шинэчлэх зэрэг заалтыг тусгаж оруулснаар архивын уншлагын танхимд их засвар хийж засвар тохижилтонд нийт 2 000 000 гаруй төгрөгийн хөрөнгийг зарцууллаа.



Хөмрөг үүсгэгч байгууллагын баримт бичигт тооллого явуулах төлөвлөгөө, график гарган ажилласнаар 2018 оны эхний хагас жилд 3 хөмрөгийн 186 ХН-д иж бүрэн тооллого явуулж, тооллого явуулсан тухай акт үйлдэн хэрэгт баяжилт хийлээ.

“Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор эрэлт хэрэгцээ ихтэй, байнга ашиглагддаг баримтанд хамгаалалтын ба ашиглалтын хувь үйлдэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2018 он гарсаар дараах ажлыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- 17 хөмрөгийн 397 ХН буюу 22300 хуудас баримтанд тодорхойлон бичилт хийж;
- 14 хөмрөгийн 411 хадгаламжийн нэгж буюу 21846 хуудас баримтыг скайнердаж хамгаалалтын ба ашиглалтын хувь үйлдэж;
- 18 хөмрөгийн 440 хадгаламжийн нэгж буюу 25137 хуудас баримт засварлаж;
- 17 хөмрөгийн 366 хадгаламжийн нэгж буюу 20795 хуудас баримтанд холболт хийж;
- 13 хөмрөгийн 2330 хадгаламжийн нэгж буюу 111075 хуудас баримтын дансны бүртгэл, жагсаалтыг хийх зэрэг цахимжуулалтын ажлыг хийж гүйцэтгээд байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өгсөн үүрэг даалгавар
/сайдын албан даалгавар/, хууль сахиулах байгууллагуудын
харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах талаар авч
хэрэгжүүлсэн арга хэмжээ, хамтын ажиллагааны үр дүн

Нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын талаар аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар Цагдаагийн газрын даргын сонсгол, мэдээллийг хэлэлцэн сонсож, статистик тоо, мэдээнд сар тутам дүгнэлт өгч нөхцөл байдал болон Цагдаагийн байгууллагаас гаргасан саналыг үндэслэн зохион байгуулалтын болоод бусад дэмжлэг тусалцаа үзүүлэн ажиллалаа.

Хууль зүйн сайдын 2015 оны 1/3 албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор хууль, эрх зүйн хэлтсийн харьяа газар, хэлтэс, албадын үйл ажиллагаа, ажлын

явцтай танилцах ажлыг тус хугацаанд зохион байгуулж дараах ажлыг зохион байгуулав. Үүнд:

Аймгийн хэмжээний эрүү, хэв журам, зам тээврийн нөхцөл байдалтай танилцах, цаашид авах арга хэмжээг тодорхойлох зорилгоор Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүдийг нийтийн эргүүлд гаргах хуваарийг батлан Цагдаагийн газартай хамтран ажиллалаа. Тус хуваарийн дагуу аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 17 гишүүд 2018 оны 5 сарын 1-11-ний өдрүүдэд нийтийн эргүүлд ажилласан. Цагдаагийн газраас хамтран эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн алба хаагчид зөвлөлийн гишүүдэд аймгийн хэмжээний эрүү, хэв журмын нөхцөл байдал, цагдаагийн газрын үйл ажиллагааг танилцуулан эргүүл хяналт шалгалт хийхэд тулгамдаж байгаа бэрхшээл хүндрэлийг цагдаагийн алба хаагчдын үүрэг гүйцэтгэж байгаа газар дээр нь очиж үзүүллээ. Эргүүл хийх хугацаанд замын пост, онцгой объектуудын харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэл, сургууль цэцэрлэгийн жижүүр харуул хамгаалалт, тоглоомын газар, бар ресторан, зочид буудал, архи согтууруулах ундаа худалдаалдаг аж ахуй нэгж байгууллага, гудамж гэр хорооллуудаар явж нөхцөл байдалтай танилцан хяналт шалгалт хийлээ. Эргүүл хийсэн зөвлөлийн гишүүдэд цагдаагийн албан хаагчдаас дараах саналуудыг гаргасан.



-Цагдаагийн газрын алба хаагчдын ажилд зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, унааны асуудлыг сайжруулах, нэмэгдүүлэх

-Төв зам болон гэр хорооллын гэрэлтүүлэг болон камержуулалтыг нэмэгдүүлэх, замын гэрэлтүүлгийг шөнө бүтэн асаадаг байх

-Онцгой объект, албан байгууллагын харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэх байдлыг сайжруулах

-Цахим тоглоомын газруудад нэгдсэн шалгалт хийх зэрэг саналууд гарсныг ГХУСАЗСЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажиллахаар шийдвэрлэсэн.

Аймгийн Шүүхийн шинжилгээний албанд ГХУСАЗСЗ-ийн 2018 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тус албаны үйл ажиллагааг хэвийн явуулах боломж нөхцлөөр хангахад зориулан Криминалистикийн хэсэгт шаардлага хангасан Epson L1800 A3 фото принтерийг олголоо.



➤ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолоор батлагдсан “Гэрч, хохирогчийг хамгаалах туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, аймгийн ГХУСАЗСЗ, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Хууль зүйн туслалцааны төв, Хэвлэл мэдээллийн төлөөлөл, Прокурор, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Оюуны гэгээ ТББ зэрэг байгууллагуудын дунд “Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж, үйл ажиллагааны уялдаа, хамтын ажиллагаагаа салбар, чиглэл бүрээр сайжруулах, эрчимжүүлэхэд байгууллагуудын үүрэг, чиглэлийг тодорхой болгож, харилцан ойлголцолд хүрлээ.





Хууль зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд хууль хяналтын байгууллагууд хамтран, аймгийн ГХУСАЗСЗ-өөс санхүүгийн дэмжлэг үзүүлж “Хууль зүйн үйлчилгээг нэг цэгээс үзүүлэх нь” нээлттэй хаалганы өдөрлөгийг 6 дугаар сарын 8-ны өдөр зохион байгуулж, уг үйл ажиллагаанд аймгийн ГХУСАЗСЗ, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, аймгийн Шүүх, Прокурор, Цагдаагийн газар, Хуульч эмэгтэйчүүдийн холбооны салбар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн шинжилгээний алба, Хууль зүйн туслалцааны төв, аймгийн Архивын тасаг, Улсын бүртгэлийн хэлтэс, Өмгөөлөгчдийн салбар зөвлөл зэрэг 12 байгууллага хамтран оролцлоо. Тус арга хэмжээг аймгийн Мандал худалдааны төв талбайд зохион байгуулж, энэ үеэр иргэд, олон нийтэд байгууллага бүр үйл ажиллагаагаа сурталчилахаас гадна Захиргааны ерөнхий хууль, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх, зөрчлийн тухай хуулиудаар сургалт, сурталчилгаа, мэдээлэл хийх, хууль эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, туслалцааг үзүүлж гарын авлагаар хангах, гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ мэдээлэл хийх, иргэдээс гэмт хэрэг зөрчлийн талаар мэдээ мэдээлэл хүлээн авч газар дээр нь шийдвэрлэх, галт зэвсгийн гэрчилгээг шинээр авах иргэдийн материалыг хүлээн авах, шинээр жолооны үнэмлэх авах иргэдийн материалыг хүлээн авах, жолооны үнэмлэхний лавлагаа болон оноо тоолох мэдээллийг гаргаж өгөх, шүүхийн шийдвэрээр иргэд, байгууллагад өр төлбөргүй тодорхойлолт олгох, иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, гэрлэлтийн гэрчилгээ олгох, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ олгох, хуулийн этгээдийн гэрчилгээ олгох, иргэд, албан байгууллагаас нэхэмжлэл, өргөдөл хүлээн авах, шүүхэд мэдүүлэх эрхийг хангах, байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой санал асуулга авах, өргөдөл, гомдлыг газар дээр нь шийдвэрлэх, өргөдөл бичих үйлчилгээнүүдийг тус өдөрлөгөөр Цагдаагийн 3 төрлийн үзүүлэх тоглолт, уралдаант тэмцээнийг түрүүлсэн 2 иргэнийг урамшууллаа. Мөн аймгийн сумын ГХУСАЗСЗ-өөс олон ажиллагааг нь дэмжин дугуй 2 ш, Цагдаагийн үйл ажиллагааг дэмжин хамтран ажилладаг Сайнцагаан сумын нэг Засаг дарга, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Эрдмийн далай цогцолбор сургууль, нэг иргэнийг тус тус урамшуулж талархал гардуулав.



Хууль зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд хууль хяналтын байгууллагууд хамтран, аймгийн ГХУСАЗСЗ-өөс санхүүгийн дэмжлэг үзүүлж “Хууль зүйн үйлчилгээг нэг цэгээс үзүүлэх нь” нээлттэй хаалганы өдөрлөгийг 6 дугаар сарын 8-ны өдөр зохион байгуулж, уг үйл ажиллагаанд аймгийн ГХУСАЗСЗ, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, аймгийн Шүүх, Прокурор, Цагдаагийн газар, Хуульч эмэгтэйчүүдийн холбооны салбар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн шинжилгээний алба, Хууль зүйн туслалцааны төв, аймгийн Архивын тасаг, Улсын бүртгэлийн хэлтэс, Өмгөөлөгчдийн салбар зөвлөл зэрэг 12 байгууллага хамтран оролцлоо. Тус арга хэмжээг аймгийн Мандал худалдааны төв талбайд зохион байгуулж, энэ үеэр иргэд, олон нийтэд байгууллага бүр үйл ажиллагаагаа сурталчилахаас гадна Захиргааны ерөнхий хууль, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх, зөрчлийн тухай хуулиудаар сургалт, сурталчилгаа, мэдээлэл хийх, хууль эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, туслалцааг үзүүлж гарын авлагаар хангах, гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ мэдээлэл хийх, иргэдээс гэмт хэрэг зөрчлийн талаар мэдээ мэдээлэл хүлээн авч газар дээр нь шийдвэрлэх, галт зэвсгийн гэрчилгээг шинээр авах иргэдийн материалыг хүлээн авах, шинээр жолооны үнэмлэх авах иргэдийн материалыг хүлээн авах, жолооны үнэмлэхний лавлагаа болон оноо тоолох мэдээллийг гаргаж өгөх, шүүхийн шийдвэрээр иргэд, байгууллагад өр төлбөргүй тодорхойлолт олгох, иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, гэрлэлтийн гэрчилгээ олгох, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ олгох, хуулийн этгээдийн гэрчилгээ олгох, иргэд, албан байгууллагаас нэхэмжлэл, өргөдөл хүлээн авах, шүүхэд мэдүүлэх эрхийг хангах, байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой санал асуулга авах, өргөдөл, гомдлыг газар дээр нь шийдвэрлэх, өргөдөл бичих үйлчилгээнүүдийг тус өдөрлөгөөр Цагдаагийн 3 төрлийн үзүүлэх тоглолт, уралдаант тэмцээнийг түрүүлсэн 2 иргэнийг урамшууллаа. Мөн аймгийн сумын ГХУСАЗСЗ-өөс олон ажиллагааг нь дэмжин дугуй 2 ш, Цагдаагийн үйл ажиллагааг дэмжин хамтран ажилладаг Сайнцагаан сумын нэг Засаг дарга, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Эрдмийн далай цогцолбор сургууль, нэг иргэнийг тус тус урамшуулж талархал гардуулав.

тус үзүүллээ. Тус газраас “Бие хамгаалах” иргэдийн дунд “АХА” зохион байгуулж, аймгийн ГХУСАЗСЗ-өөс төвийн Сайнцагаан нийтийн 2 цагдаад үйл унадаг газрын багийн

Онцгой байдлын газрын дэргэдэх Аюулаас сэрэмжлүүлэх цогцолборын радио долгионы 107,5-аар сар бүрийн тогтсон өдрүүдэд хууль, эрх зүйн хэлтсийн харьяаны хэлтэс, албадууд хууль тогтоомж болон өөрийн байгууллагын цаг үеийн ажилтай холбогдсон мэдээлэл сурталчилгааг тогтмол зохион байгуулж байна. Мөн бага насны хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх үүднээс “School police”-г явуулж, эцэг эхчүүдийг энэ үйл ажиллагаанд татан оролцуулж сургууль, цэцэрлэгийн гадна талд эргүүлийн үүрэг байнга гүйцэтгэж байна.

дарга нартай хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний биелэлтийг хангахад зохион байгуулалтын арга хэмжээ авах, гэрээний биелэлтийн тайлан мэдээ, дараа оны гэрээнд тусгах саналыг нэгтгэх талаар

Хууль зүй, дотоод хэргийн сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэстэй хамтран явцын үнэлгээ хийж цаашид гэрээний хэрэгжилтийг үр дүнтэй эрчимжүүлэх талаар зөвлөмж өгч ажиллалаа. Гэрээний хэрэгжилт 2018 оны эхний хагас жилийн байдлаар 80.36 хувийн хэрэгжилттэй байна./Гэрээний хэрэгжилтийг тайланд хавсаргав/
Цагдаагийн албаны тухай хуулийн 94.1, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тус аймгийн Засаг даргатай 2018 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний 3.7, 3.9 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээнд “Суманд ажиллаж буй цагдаагийн кобаны байрны хэсгийн цахилгаан зөвхөн ажлын байрны дулаан, түлш, шатахуун, бичиг хэрэг, унаа, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх, гэр бүлийн гишүүдэд дэмжлэг үзүүлэх, ажлын байраар хангах талаар” тусган зохицуулж, хөдөө сумдад 28 алба хаагч албаны байранд гэр бүлтэйгээ амьдарч, гэр бүлийн гишүүдийг ажлын байраар хангаж байна. 2018 оны эхний хагас жилд Гэмт хэрэг, зөрчил хамгийн их гардаг, аймгийн төв орох зам дагуу байршилтай Дэлгэрцогт, Баянжаргалан сумд Орон нутгийн хөгжлийн сангаасаа цагдаагийн хэсгийн үйл ажиллагааг дэмжин 4.0 сая төгрөгөөр бэлэн бус торгуулийн төхөөрөмжөөр хангаж, Хулд сум ОНХС-аас сумын төвийн болон төв замын мал явдаг газраар замын тэмдэг тэмдэглэгээ хийх, үхэр малыг гэрэлтдэг хүзүүвчтэй болгоход 2,0 сая төгрөг зарцуулсан. Хамгийн олон хүн амтай Эрдэнэдалай сумын цагдаагийн хэсгээ дэмжин мотоциклоор хангасан, Сайнцагаан сумын Засаг дарга Цагдаагийн хэсэгтээ 1 ширхэг нисдэг дрон камер шийдэж, Замын хяналтын постод 3.5 сая төгрөгний засвар үйлчилгээ хийсэн. Мөн сумын ГХУСАЗСЗ-өөс Олон нийтийн 2 цагдаад үйл ажиллагааг нь дэмжин 2 ш унадаг дугуй олгох зэргээр гэрээний биелэлтийг хангаж ажиллаж байна.

Хүний эрхийн талаархи хууль тогтоомж, иргэд, байгууллагад сурталчлах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан ажлын үр дүнгийн талаар

Аймгийн хууль хяналтын байгууллагуудтай болон “Хуульч эмэгтэйчүүдийн холбооны салбар”, “Оюуны гэгээ” зэрэг ТББ-уудтай хамтран иргэдэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хууль зүйн зөвлөгөө өгөх ажлуудыг хамтран хэрэгжүүлж байна. Үүнд:

- Аймгийн ГХУСАЗСЗөвлөл, Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, “Дэлхийн зөн Дундговь” ОНХХ-тэй тус тус хамтран хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, осол, хүчирхийлэлд өртсөн иргэд, хүүхдийн мэдээллийг хүлээн авч, шалган, хүчирхийллийг таслан зогсоох, аюулгүй байдлыг хангах, нөхцөл байдлын үнэлгээ хийж, мэргэжлийн цогц үйлчилгээг багаар үзүүлэх чадвар эзэмшүүлэх зорилгоор сумдын хамтарсан багийн 154 гишүүнийг хамруулан лекц, бүлгийн ажил, хэлэлцүүлэг, оролцооны аргуудыг ашиглан сургалт зохион байгуулж, тэдэнд гэр бүл, хүүхдийн эрхийн зөрчилд яаралтай хариу үйлчилгээ үзүүлэх чадварыг эзэмшүүлсэн.

- Дэлхийн зөн Дундговь ОНХХ, Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран хүүхдийг нийгмийн бүх орчинд хүчирхийлэлд өртөх, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх хамгаалах зорилгоор “ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТАСЛАН ЗОГСООХОД ЭХ ДЭЛХИЙГЭЭРЭЭ НЭГДЬЕ” аяныг зохион байгууллаа. Аяны хүрээнд иргэд, олон нийтэд “Хүүхдийн эрх, хамгаалал”, “Хүүхэд

хүмүүжүүлэх эерэг арга”, “Гэр бүлийн хурал, дүрэм”, “Хүүхдийн эрх, хамгаалал”, “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэхэд олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх” сэдвээр, ЕБС-ийн сурагчдад “Өөрийгөө болон үе тэнгийнхнийгээ хүүхдийн эрхийн зөрчлөөс хамгаалж сурахад дэмжлэг үзүүлэх” сэдвээр сургалт сурталчилгаа, зөвлөгөө, мэдээллийн ажлыг зохион байгуулж, дээрх чиглэлээр хууль тогтоомжийн зөвлөгөө мэдээлэл өгсөн. Аянд тус аймгийн Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Луус, Хулд, Адаацаг, Сайнцагаан сумдын 703 хүүхэд, 995 эцэг эх, асран хамгаалагч нийт 1698 иргэнд хүүхэд хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх ойлголт мэдлэг нэмэгдсэн.

- “Лантуун дохио” ТББ, Сайнцагаан сумын ГХУСАЗСЗ, “Дэлхийн зөн” ОНХХ-тэй хамтран Хүчирхийлэл, цахим гэмт хэрэг ба түүний хор уршиг, хүний наймаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор “НЭГ АМЬ НЭГ МЭДЭЭЛЭЛ” лекцийг зохион байгуулж, МСҮТ, ЕБС-иудын 9-12 дугаар ангийн 1450 сурагч, 34 хүртэлх насны 195 залуучуудыг хамрууллаа.

- Цагдаагийн газар, БСУГ-тай хамтран баруун бүсийн 6 сумын ЕБС-ийн 6-12 дугаар ангийн 1032 сурагчид Зам тээврийн болон ахуйн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлыг 964 сурагчдад зохион байгуулсан.

- Аймгийн ЦГ, ГБХЗХГ-тай хамтран Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг автомашингүй өдөр болгож “Хүүхэд бүр гэр бүлдээ аз жаргалтай” сэдвийн хүрээнд 2018.06.01-ний өдөр Дундговь аймгийн холбогдох байгууллагууд соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулж, тэмдэглэн өнгөрүүллээ.

Хүний эрхийн үндэсний комиссын аймаг дахь төлөөлөгч, Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч нар орон тоогоор ажиллаж үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна. Тус хоёр ажилтны ажиллах нөхцлийг ханган аймгийн Засаг даргын Тамгын газарт ажлын өрөөгөөр хангасан.

Тус оны эхний хагас жилд Хууль зүйн туслалцааны төвөөс хууль зүйн зөвлөгөөг 145 иргэнд хууль зүйн болон өмгөөллийн туслалцаа үзүүллээ. Үүнээс шүүхээр 13 холбогдогчтой 13 хэрэг, шүүхийн өмнөх шатанд 1 холбогдогчтой 1 хэргийг шийдвэрлэж, шүүхээр шийдвэрлэгдээгүй 4 хэргийн 5 холбогдогчтой хэрэг хүлээгдэж байна.

Хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч “Хууль зүйн үйлчилгээг нэг цэгээс үзүүлэх нь” нээлттэй хаалганы өдөрлөгт хуулийн байгууллагуудтай хамтран оролцож 20 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгөхөөс гадна иргэдэд өргөдөл бичих үйлчилгээг үзүүллээ.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг /2016-2019 онд/ хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 204 дүгээр тогтоолыг хяналтанд авч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газартай хамтран “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль”-ийг “Сайнцагаан-Сүүн Сайнцагаан” орон нутгийн сонинд нийтлүүлэн иргэдэд сурталчилж ажиллалаа.

Санал, хүсэлт:

Тус Хууль, эрх зүйн хэлтсийн 2018 оны эхний хагас жилийн тайлан, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хэрэгжилттэй холбоотой дараах санал байгааг уламжилж байна. Үүнд:

1. Цагдаагийн албаны тухай хууль(шинэчилсэн найруулга)-ийн 94 дүгээр зүйлийн 94.1, ХЗДХ-ийн сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан 2018 оны хамтран ажиллах гэрээний 3.7-г тус тус үндэслэн аймгийн Засаг даргаас сумдын Засаг даргатай 2018 онд



байгуулсан гэрээнд суманд ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчийг орон байр(урсгал зардал) тээвэр, холбооны хэрэгслээр хангах талаар тусган хэрэгжүүлж байна. Гэвч Цагдаагийн албаны тухай хууль(шинэчилсэн найруулга)-ийн 94 дүгээр зүйлийн 94.1 дэх заалт нь Төсвийн тухай хуулийн:

-“3.4.Төсвийн харилцааг зөвхөн энэ хуулиар зохицуулах бөгөөд орон нутаг, салбарын үйл ажиллагаанд санхүүжилтийн эх үүсвэрийн хэмжээг хуульчлан тогтоох, түүнийг хуваарилах аливаа харилцаа үүнд нэгэн адил хамаарна”,

-“6.6.5.Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэхээр энэ хуульд заасан чиг үүргээс бусад чиг үүргийг өөр хууль тогтоомжоор тогтоосон бол тухайн чиг үүргийг санхүүжилтийнх нь хамт шийдвэрлэн, шилжүүлдэг байх”

-“6.6.6.Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн зохицуулалттай зөрчилдөж байгаа тул сумдад баригдсан Цагдаагийн кобаны урсгал зардлыг цаашид орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхэд хүндрэлтэй байдал үүсгэж байгааг зохицуулах,

2. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлээр орон нутагт “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн нэлээд хэмжээний хөрөнгө хуваарилагдах болсон. Энэхүү хөрөнгөөр орон нутагт үйл ажиллагаа явуулж буй Улсын төсвийн байгууллагуудад хөрөнгө оруулалт хийх, техник тоног төхөөрөмжөөр хангах шаардлага гарахад төсвийн тухай хуулийн дээрх 6.6.5, 6.6.6 дахь зарчим, заалтуудаар тус тус хязгаарлагдаж, томоохон дэмжлэг авч чадахгүй байна. Иймд Төсвийн тухай хуулийн холбогдох хэсгүүдэд өөрчлөлт оруулж орон нутагт тусгайлсан чиг үүрэг гүйцэтгэж байгаа Улсын төсвийн байгууллагууд/Цэрэг, Цагдаа, Онцгой байдал гэх мэт/-д Орон нутгийн хөгжлийн сангаас хөрөнгө оруулалт хийх, техник, тоног төхөөрөмжөөр хангаж болох талаар оруулах хэрэгтэй байна.

3. ХЗДХ-ийн сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан 2018 оны хамтран ажиллах гэрээний 3.7, 3.8, 3.12 дахь заалтуудад Цагдаагийн албаны тухай хуулийн 37, 38, 39-р зүйлийг эрх зүйн үндэслэл болгон тусгасан хүчингүй нь оновчгүй байна.

4. Хууль, эрх зүйн хэлтсүүдийн 2017 оны ажлын үнэлгээ өнгөрсөн хугацаанд албан бичгээр ирсэн. Харин 2016 оны ажлаар тус хэлтэс аймгуудын хэмжээнд 3 дугаар байранд шалгарсан боловч үнэлсэн дүнг албан бичгээр ирүүлээгүй, ХЗДХСайдын 2017 оны А/182 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу шагнал урамшил олгоогүй асуудлыг судлан шийдвэрлэж өгнө үү.

ТАЙЛАН БИЧСЭН: ХЭЗХ-ИЙН АХЛАХ

МЭРГЭЖИЛТЭН

С.ЦЭНГЭЛМАА

ТАЙЛАН ХЯНАСАН:

ХЭЗХ-ИЙН ДАРГА

Б.ТҮВШИНБАЯР

Дундговь аймаг

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СИСТЕМЧЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ,
ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ТУСЛАЛЦААНЫ ТАЛААРХ 2018 ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН МЭДЭЭ

Д/д	Ажлынчиглэл	Үзүүлэлт		Сум,	Хууль, эрх зүйн хэлтэс	Бүгд
1	Хуультогтоомжийн системчлэл мэдээлэл	Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санд байгаа эрх зүйн актын тоо		“Төрийн мэдээлэл”	4073	4073
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санг шинээр баяжуулсан эрх зүйнактын тоо		сэтгүүл болон www.legalinfo.mn сайт ашигладаг	148	148
		Системчлэл хийсэн хууль тогтоомж		-	-	-
		Өөрчлөлт хөдөлгөөн хийсэн зүйл заалтын тоо		-	91	91
		Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системээс лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	10	23	33
			Байгууллага	5	5	10
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн гар сангаас лавлагаа, мэдээлэл өгсөн	Иргэд	21	21	42
Байгууллага	4		4	8		
2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянах	Хянаж санал өгсөн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамж		620	271	891
		Үүнээс захиргааны хэм хэмжээ тогтоосон захирамж	Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж бүртгүүлсэн	1	-	1
			Хууль зүй, дотоод хэргийн яамнаас дүгнэлт гаргаж буцаасан	-	1	1
3	Эрх зүйн сургалт, сурталчилгаа	Зохион байгуулсан эрх зүйн сургалт, хэлэлцүүлэг		124	10	134
		Үүнээс сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан хүний тоо		4498	944	5442
		Зохион байгуулсан эрх зүйн сурталчилгаа		20	3	23
		Боловсруулсан гарын авлага, сургалт, сурталчилгааны материал		1270	1690	2960
		ФМ, Радио, телевизийн нэвтрүүлэг		8	14	22
		Сонин хэвлэлээр сурталчилсан		8	2	10
		Бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан		3	2	5

МЭДЭЭГ ГАРГАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН С.ЦЭНГЭЛМАА
МЭДЭЭГ ХЯНАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Б.ТҮВШИНБАЯР